



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 03/04

Арвайхээр

Аймгийн 2021 оны хөгжлийн
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2."а", Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, бүтэн жилээр дүгнэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг аймгийн Засаг дарга /А.Ишдорж/-д даалгасугай.

ДАРГА



О.ПҮРЭВДОРЖ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2020 оны 12. дугаар сарын 02.-ны өдрийн
03/04. дүгээр тогтоолын хавсралт



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН 2021 ОНЫ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зорилт, арга хэмжээ	Шаардагдах хөрөнгийн эх үүсвэр	Хариуцах байгууллага
1	2	3	4
НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ			
Зорилго: Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар дундаж давхаргын хамрах хүрээг өргөжүүлэн, гэр бүлд ээлтэй жендэрийн мэдрэмжтэй цогц бодлого хэрэгжүүлнэ.			
ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ӨВ СОЁЛ			
Зорилт 1.1. Эх хэл, соёл, ёс заншлаа дээдэлсэн эх оронч үзэлтэй эв нэгдлийг эрхэмлэсэн иргэнийг төлөвшүүлэн хөгжүүлж, түүх, соёлын өвөө хамгаалан, үндэсний бахархлаа түгээн дэлгэрүүлж, соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.			
1.	Угийн бичиг, монгол бичгийн бүх нийтийн хэрэглээг нэмэгдүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, соёлын биет болон биет бус өвийг хамгаалах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх “Соёлын өв-Хөгжлийн дархлаа” цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Орон төсөв нутгийн	Боловсрол соёл, урлагийн газар /цаашид БСУГ гэх/
2.	“Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд нийтийн бүжиг, явган алхалтыг зохион байгуулах санал санаачилгыг дэмжин, орон нутгийн соёл, урлагийн үйлчилгээнд иргэдийн оролцоо, цахим орчин дахь үндэсний соёлын нөлөөг нэмэгдүүлнэ.	-	БСУГ
3.	“Уран бүтээлийн нэгдэл” байгуулж, “Эрдэнийн эрэлд” соёлын цуврал контентыг бэлтгэж иргэдэд хүргэнэ.	Орон төсөв нутгийн	БСУГ, аймгийн Хөгжимт драмын театр /цаашид ХДТ гэх/
4.	Соёлын биет бус өвийг хамгаалах зорилгоор “Соёлын өв хөгжлийн дархлаа” форумаас гаргасан Арвайхээрийн тунхаглалыг хэрэгжүүлнэ.	Орон төсөв нутгийн	БСУГ

5.	Төв халхын уртын дуу, морин хуурын наадам, Хүүхэд залуучуудын урлагийн их наадмыг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан оновчтой хэлбэрийг сонгон зохион байгуулна.	Орон төсөв	нутгийн	БСУГ
Зорилт 1.2. Соёл, урлагийн байгууллагын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн соёлын үйлдвэрлэлийг дэмжих замаар үйлчилгээний чанар, хүртээмжийг өргөжүүлэн, мэргэжлийн хүний нөөцөөр хангана.				
6.	Эрдэнэзуу музейн Лаврин хийдийн барилгын их засвар, Баянгол сумын Соёлын төвийн барилга угсралтын ажлыг дуусгах, аймгийн Музейн барилга угсралтын ажлыг үргэлжлүүлнэ.	Улсын төсөв		Аймгийн Засаг даргын Тамгын газар /цаашид аймгийн ЗДТГ гэх/, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /цаашид ГХБХБГ гэх/
7.	Хөгжимт драмын театрын гэрэлтүүлэг, дууны техник, уран бүтээлчдийн хувцас, Хархорин, Уянга сумдын Соёлын төвийн гэрэлтүүлэг, Хархорин, Баруунбаян-Улаан, Өлзийт сумдын Соёлын төвийн үзэгчийн сандлыг шинэчилнэ.	Улс, нутгийн төсөв	орон	БСУГ, ХДТ
8.	Өлзийт, Баян-Өндөр, Зүүнбаян-Улаан сумдын Соёлын төвийг засварлана.	Улс, нутгийн төсөв	орон	БСУГ
Зорилт 1.3. Орон нутгийн соёл, урлагийн үйл ажиллагааны менежментийг сайжруулж, гадаад харилцааг хөгжүүлнэ.				
9.	Иргэдэд соёл, урлагийн үйлчилгээг зайны болон нүүдлийн хэлбэрээр хүргэж, аймгийн Төв номын санг компьютерээр хангаж, номын сангийн цахим үйлчилгээг хөгжүүлнэ.	-		БСУГ
10.	“Өндөр гэгээнтний цогцолбор” төсөл боловсруулж, “Өндөр Гэгээний соёлын өв уламжлагч” улсын уралдааныг зохион байгуулан соёл урлаг, уран бүтээл, урлалын цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Улсын төсөв		БСУГ, Байгаль орчин аялал жуулчлалын газар /цаашид БОАЖГ гэх/
ЭРҮҮЛ МЭНД				
Зорилт 1.4. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.				
11.	Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг сайжруулж, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.	Улсын төсөв		Эрүүл мэндийн газар /цаашид ЭМГ гэх/
12.	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд “Эрүүл мэндийг дэмжих төв” байгуулж, иргэн бүр урьдчилан	Улсын төсөв		ЭМГ

	сэргийлэх, эрт илрүүлэх хорт хавдрын 7 төрөл, артерийн даралт ихсэх, чихрийн шижингийн эрт илрүүлгийн эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамруулна.		
13.	Иргэдийн дунд эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт зан үйлийн тархалтыг бууруулах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд: -Хүн амын хоол тэжээл зохистой хооллолт, илүүдэл жин, таргалалттай тэмцэх -давсны хэрэглээг бууруулах арга хэмжээ -Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, хорт зуршил, мансууралтай тэмцэх арга хэмжээ -Арьс, харшлын өвчнийг бууруулах арга хэмжээ -Осол, гэмтлээс сэргийлэх арга хэмжээ -Хэрх, хэрх төст өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ. -Хеликобактергүй гэр бүл арга хэмжээ	Улсын төсөв	ЭМГ, Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд
14.	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах, бууруулах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд: -Орчны эрүүл мэндийг сайжруулах арга хэмжээ -Сүрьеэ өвчинтэй тэмцэх арга хэмжээ -БЗХӨ /ДОХ/ Тэмбүү өвчнийг бууруулах арга хэмжээ -Томуу, томуу төст өвчнийг бууруулах арга хэмжээ -Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ -“Элэг бүтэн-Монгол” арга хэмжээ	Улсын төсөв	ЭМГ, Зооноз өвчин судлалын төв, Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд
15.	Нөхөн үржихүйн эрүүл мэндийг сайжруулах арга хэмжээ - Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ - Эрчүүдийн эрүүл мэндийг дэмжих арга хэмжээ - Өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих арга хэмжээ.	Улсын төсөв	ЭМГ
Зорилт 1.5. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлнэ.			
16.	Эрүүл мэндийн салбарт эмнэлзүйн олон улсын стандарт UpToDate платформ, бүртгэл, нэвтрүүлнэ.	Улсын төсөв	ЭМГ
17.	Эм зүйн тусламж үйлчилгээнд хяналтын цахим тогтолцоог нэвтрүүлэн, эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Улсын төсөв	ЭМГ
Зорилт 1.6. Цахим эрүүл мэнд, эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлж, яаралтай тусламжийн чанар, үйлчилгээг сайжруулна.			
18.	Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сумын Эрүүл мэндийн төвдүүдэд мобайл технологийг	Улсын төсөв	Аймгийн ЗДТГ, ЭМГ

	нэвтрүүлнэ.		
19.	Оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглах, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ.	Улсын төсөв	ЭМГ
20.	Цэргийн үзлэгийн хяналт, жирэмсний нэрийн хяналтад цахим программыг нэвтрүүлнэ.	Улсын төсөв	ЭМГ
21.	Яаралтай тусламж үзүүлдэг нэгжийн тоог нэмэгдүүлж, эмч, мэргэжилтнийг багаар нь чадавхжуулна.	Хувийн хэвшил	ЭМГ
22.	Осол гэмтлийн дуудлага ихтэй Хархорин, Хужирт, Богд сумдад гэмтлийн нарийн мэргэжлийн тусламжийг үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	Улсын төсөв	ЭМГ
Зорилт 1.7. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бүрдүүлж, чадавхыг дээшлүүлэн, нийгмийн хамгааллыг дэмжинэ.			
23.	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг резиденсийн сургалт эрхэлдэг байгууллага болгоно.	Улсын төсөв, төсөл хөтөлбөр	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв /цаашид БОЭТ гэх/
24.	Эмнэлгийн эмчилгээний хоол, шим тэжээлийн мэргэжилтнийг бэлтгэнэ.	-	ЭМГ
Зорилт 1.8. Эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандартын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.			
25.	Зоонозын өвчин судлалын төв, Богд, Хужирт сумдын Эрүүл мэндийн төвийн өргөтгөл, Уянга сумын эмчийн байрыг тус тус шинээр барьж, уламжлалт, нөхөн сэргээх, амбулатори, шүдний гажиг засал, сувилахуй зэрэг эмнэлгүүдийг хувийн хэвшилд тулгуурлан байгуулж, Нарийнтээл сумын Баянтээг багийн эмнэлгийн сэргээн засах уламжлалт эмчилгээний үйл ажиллагааг нэмэгдүүлнэ.	Улсын төсөв	Аймгийн ЗДТГ, ЭМГ, ГХБХБГ
26.	Хархорин сумын нэгдсэн эмнэлгийн барилгын их засвар хийж, чих хамар хоолойн тусламж үйлчилгээний багажаар хангаж, Зүүнбаян-Улаан сумын Эрүүл мэндийн төвийн сантехникийн засвар, Нарийнтээл сумын Эрүүл мэндийн төвийн халдвартын тасгийн засвар, Хужирт, Тарагт сумдын эмчийн байрны их засварыг тус тус хийж, зарим сумдын эмнэлгийн хог хаягдлыг орчин үеийн дэвшилтэт технологиор устгаж, нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар солих, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн хүүхдийн эмнэлгийн хатуу зөөлөн эдлэл, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	Улсын төсөв	Аймаг сумдын ЗДТГ, ЭМГ
27.	Сумдын Эрүүл мэндийн төвийг эрчимт эмчилгээний ороор хангах, шаардлагатай сумдын Эрүүл мэндийн төвүүдийн эмнэлгийг түргэн тусламжийн авто машинаар хангах ажлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.	Улсын төсөв	Аймаг сумдын ЗДТГ, ЭМГ
28.	Есөнзүйл, Сант, Баруунбаян-Улаан, Бүрд сумдын Эрүүл мэндийн төвүүдийн мооргийн барилгыг	Улсын төсөв	Аймаг сумдын ЗДТГ,

	шинээр барьж, Бат-Өлзий, Гучин-Ус, Богд, Хайрхандулаан, Өлзийт сумдын Эрүүл мэндийн төвүүдийн мооргийн барилгыг засварлана.		ЭМГ
БИЕИЙН ТАМИР			
Зорилт 1.9. Гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх замаар гэр бүлийн хөгжлийг дэмжиж, тогтвортой, чадавхжсан гэр бүлийг төлөвшүүлнэ.			
29.	Аймгийн хэмжээнд төр, хувийн хэвшлийн байгууллагуудад “Биеийн тамир, спортын хамтлаг” байгуулах ажлыг эрчимжүүлнэ.	-	Биеийн тамир, спортын газар /цаашид БТСГ гэх/
30.	Иргэдэд зориулсан биеийн тамирын гадна талбай, алхалтын зам барьж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ээлтэй орчин бүрдүүлнэ.	Орон төсөв	нутгийн БТСГ, сумдын ЗДТГ
Зорилт 1.10. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпийн түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.			
31.	Спортын 4-өөс доошгүй төрлөөр өсвөрийн шигшээ багийг байгуулна.	Орон төсөв	нутгийн Аймгийн ЗДТГ, БТСГ
32.	Үндэсний болон багийн спортын олон улсын жишигт нийцсэн зуны спортын цэнгэлдэх хүрээлэн, талбай байгуулна.	Орон төсөв	нутгийн Аймгийн ЗДТГ, БТСГ
33.	Спортын ордонд засвар хийж, узель, техник хэрэгслээр хангана.	Орон төсөв	нутгийн БТСГ
34.	“Усан спорт сургалтын төв”-ийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, үйл ажиллагааг тогтмолжуулна.	Орон төсөв	нутгийн Аймгийн ЗДТГ, Усан спорт, сургалтын төв
БОЛОВСРОЛ			
Зорилт 1.11. Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.			
35.	Сант сумын 240 хүүхдийн, Арвайхээр сумын 320, 240 хүүхдийн ерөнхий боловсролын сургуулийн барилгын ажлыг дуусгах, Бат-Өлзий, Өлзийт сумдын сургуулийн барилгыг шинээр, Уянга сумын Жаргалант баг, Арвайхээр сумын 4 дүгээр сургуулийн өргөтгөлийн барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.	Улсын төсөв	Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /цаашид ХОХБТХ гэх/, ГХБХБГ
36.	Арвайхээр, Бат-Өлзий сумдад 150 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилгын ажлыг эхлүүлэх, Хужирт суманд урлаг заал бүхий цэцэрлэгийн барилгын өргөтгөл барина.	Улсын төсөв	ХОХБТХ, ГХБХБГ

37.	Хархорин сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуульд дотуур байр шинээр барина.	Улсын төсөв	ХОХБТХ, ГХБХБГ
38.	Зарим сумдын сургууль, цэцэрлэгт мах, ногооны зориулалтын хөргүүр бүхий агуулах, зоорь барина.	Улсын төсөв	ХОХБТХ, ГХБХБГ БСУГ
Зорилт 1.12. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны сургалтын болон үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор дараах барилгуудад их засвар хийнэ.			
39.	Төгрөг, Бүрд сумдын Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байрны их засвар, Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд их засвар хийнэ.	Улсын төсөв	ХОХБТХ, ГХБХБГ БСУГ
40.	Сургууль, цэцэрлэгийг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох ажлыг эхлүүлнэ.		ХОХБТХ, ГХБХБГ БСУГ
41.	Хайрхандулаан, Уянга сумын 2 дугаар сургуулиудад сантехникийн засвар, Есөнзүйл сумын цэцэрлэгийн сантехник, агааржуулалт, Нарийнтээл сумын цэцэрлэгийн засварыг хийнэ.		ХОХБТХ, ГХБХБГ БСУГ
42.	Сургууль, цэцэрлэгийн орчны эрсдэлийн үнэлгээг улирал бүр хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг зохион байгуулна.		БСУГ
Зорилт 1.13. Боловсролын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хийж, багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.			
43.	Баруунбаян-Улаан, Төгрөг, Баянгол, Арвайхээр сумын “Тэмүүлэл-Эрдэм” сургуулиудад “Физик”-ийн, Бат-Өлзий, Зүүнбаян-Улаан, Хужирт, Нарийнтээл, Тарагт, Уянга сумын 2 дугаар сургуулиудыг “Хими”-ийн кабинетын тоног төхөөрөмжөөр хангана.	Улсын төсөв	ХОХБТХ, БСУГ
44.	Тарагт, Уянга, Нарийнтээл, Бат-Өлзий сумдын сургуулийн дотуур байр, Арвайхээр сумын Тэмүүлэл-Эрдэм, Бат-Өлзий, Сант, Есөнзүйл, Нарийнтээл сумдын Ерөнхий боловсролын сургуулийг шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангана.		БСУГ
45.	Бат-Өлзий сумын 1, Хужирт сумын 1, 2, Хархорин сумын 3, Баянгол сумдын цэцэрлэг, Хужирт, Төгрөг, Баян-Өндөр, Гучин-Ус, Өлзийт, Богд, Уянга сумын Жаргалант багийн сургуулийн дотуур байрууд, Бат-Өлзий сумын Ерөнхий боловсролын сургуульд орчин үеийн стандартад нийцсэн дуу, дүрс бичдэг хяналтын камераар хангана.		БСУГ
46.	Арвайхээр сумын 14 дүгээр шинэ цэцэрлэгийн гадна талбайн тохижилтыг MNS-6558:2015 стандартын шаардлагад нийцүүлэн жишиг байдлаар тохижуулж, зарим цэцэрлэгийн тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлнэ.		БСУГ
47.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамран сургалтыг нэмэгдүүлж, шаардлагатай тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангана.	Төсөл, хөтөлбөр	БСУГ
48.	Японы хүүхдийг ивээх сангаас “Монгол Улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах	Төсөл хөтөлбөр	БСУГ, Японы

	зарчмыг дэмжих нь”, Бат-Өлзий, Богд, Гучин-Ус, Сант, Уянга, Хархорин, Хужирт сумдад “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.		хүүхдийг ивээх сан
Зорилт 1.14. Сургууль бүрийг стандартын шаардлага хангасан гал тогоо, тоног төхөөрөмж, хүний нөөцийг бүрдүүлж, бүх сурагчдыг үдийн хоол хөтөлбөрт хамруулна.			
49.	Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн суралцагчдыг “Үдийн хоол”-оор бүрэн хангана.	Улсын төсөв	БСУГ
50.	Уянга сумын Жаргалант баг, Хархорин сумын 2, Есөнзүйл, Нарийнтээл сумдын сургуулийг гал тогооны шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	Улсын төсөв	БСУГ
51.	Сургууль, цэцэрлэгүүдэд туслах аж ахуй, хүлэмжийн аж ахуй эрхлэхэд дэмжлэг үзүүлж, зарим сургуульд хоол үйлдвэрлэлийн технологич, хоол зүйчийг орон тоогоор ажиллуулах ажлыг судалж эхлүүлнэ.	Улсын төсөв, төсөл хөтөлбөр	БСУГ
Зорилт 1.15. Боловсролын үйлчилгээг чанартай зохион байгуулж, сургалтын чанарыг дээшлүүлнэ.			
52.	Багш, удирдах ажилтны ажлын арга барил, үйл ажиллагааны үр дүн, ур чадварын түвшин тогтоох, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор багш, удирдах ажилтныг аттестатчилах ажлыг үе шаттай зохион байгуулна.		БСУГ
53.	Улсын хэмжээний “Техник, технологийн төрөлжсөн олимпиад”, анги нийтийн аймгийн олимпиад уралдаан, хөдөөгийн багш нарын спортын XIX наадмыг аймагт зохион байгуулна.	Улс, орон нутгийн төсөв	БСУГ
54.	“Шатар” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.		БСУГ
55.	Багш нарын мэргэжил боловсролыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох, багшийн ажлын үнэлэмжийг дээшлүүлэх зорилгоор “Чадварлаг багш” арга хэмжээ, “Бүсийн төвийн журам”-ын хэрэгжилтийг хангана.	Улс, орон нутгийн төсөв	БСУГ
Зорилт 1.16. Сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйд Монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний хөгжил, төлөвшил, хос бичигтэн, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийг тусган хэрэгжүүлнэ.			
56.	Монгол бичигт суралцах бүх нийтийн хөдөлгөөн өрнүүлж, хос бичигтэн аянг эхлүүлнэ.	-	БСУГ, Насан туршийн боловсролын төв /цаашид НТБТ гэх/
57.	“Миний Өвөрхангай” сургалтын хөтөлбөр боловсруулж, ном гарын авлага хэвлүүлэн сургалтад ашиглан, олны хүртээл болгож, аймаг байгуулагдсаны өдрийг угтан сарын аян зохион байгуулж хэрэгжүүлнэ.	-	БСУГ, НТБТ
58.	Хүүхдийн зуны амралтыг үр бүтээлтэй өнгөрүүлэх, тэднийг хөдөлмөрт сургах, хамтарч ажиллах	Орон нутгийн	БСУГ, сумдын ЗДТГ

	чадвар эзэмшүүлэх зорилгоор “Хөдөлмөр зуслан” төслийг хэрэгжүүлж эхэлнэ.	төсөв	
Зорилт 1.17. Нээлттэй боловсролын тогтолцоог бий болгон цахим болон зайн сургалтын нэгдсэн платформыг хөгжүүлэн, бүх шатны боловсролын сургалтын байгууллагыг цахим хэрэглээнд бүрэн шилжүүлж, бүх насны суралцагч, иргэдэд зориулсан цахим сургалтын хөтөлбөр, агуулга боловсруулан түгээнэ.			
59.	Нарийнтээл сумын Баянтээг багийн бага сургууль, цэцэрлэгийг интернет сүлжээнд холбож, Уянга сумын Жаргалант багийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийг үүрэн холбооны утасгүй интернетээр хангана.	Орон төсөв	нутгийн БСУГ
60.	Насан туршийн боловсрол олгох сургалтыг бизнес-амьдрах ухааны, ёс суртахуун-төлөвшлийн, гоо зүйн, гэр бүлийн, байгаль орчны, иргэний боловсрол олгох гэсэн чиглэлээр сургалтын олон талт хэлбэрээр зохион байгуулна.	-	НТБТ
61.	Суралцагчдын тест, сорил, шалгалтын материалыг богино хугацаанд үнэлж, үр дүн, тайлан мэдээллийг олон төрлөөр боловсруулах хүчин чадалтай программ, техник хэрэгслээр бүсийн төвийн Ерөнхий боловсролын 5 сургуулийг хангана.	Орон төсөв	нутгийн БСУГ
Зорилт 1.18. Багшлах боловсон хүчний мэргэжил арга зүйн хөгжлийг дэмжих, тэднийг урамшуулах, харилцан туршлага солилцох боломжийг олгох, тэдний нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэхэд анхаарч ажиллана.			
62.	Салбарын албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах, тэдний эрүүл мэнд, хөдөлмөрийн үнэлэмж, орон байрны нөхцөлийг сайжруулах ажлыг эхлүүлнэ.	-	БСУГ
63.	Багш, удирдах ажилтны мэргэжил боловсролыг дээшлүүлэх "Багшийн цахим кампус" зайн сургалтын системийг хөгжүүлж, багш нарын 70-аас доошгүй хувийг зайн сургалтаар мэргэжил боловсролыг нь дээшлүүлнэ.	Орон төсөв	нутгийн БСУГ
64.	Багш нарын арга зүйн хөгжлийг дэмжих тэргүүн туршлага, ур чадварыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Багш, сурагч солилцоо”-ны арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Орон төсөв	нутгийн БСУГ
65.	Арвайхээр сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуульд сэтгэл зүйчийн орон тоог шийдвэрлэн, ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.	Улсын төсөв	БСУГ
ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ			
Зорилт 1.19. Гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх замаар гэр бүлийн хөгжлийг дэмжиж, тогтвортой, чадавхжсан гэр бүлийг төлөвшүүлнэ.			
66.	Гэр бүлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор гэр бүлийн боловсрол олгох “Амьдралд тавтай морил” багц сургалтыг үе шаттай зохион байгуулж, гэрлэх насны болон шинээр гэр бүл болж буй залуучуудын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлнэ.	Улсын төсөв	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /цаашид ГБХЗХГ гэх/

Зорилт 1.20. Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулан, хүүхдэд ээлтэй аюулгүй орчин бүрдүүлнэ.			
67.	Хүүхдийн ордон, усан спорт сургалтын төвийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт хийж менежментийг боловсронгуй болгоно.	-	Аймгийн ЗДТГ
68.	Хүүхэд хамгааллын хамтарсан багийг чадавхжуулж, хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд бүртгэлтэй хүүхдүүдэд журмын дагуу үйлчилгээ үзүүлж, салбар дундын уялдааг хангаж, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ.	Улсын төсөв	ГБХЗХГ
Зорилт 1.21. Залуучуудын хөгжил, оролцоог дэмжсэн орчин нөхцөлийг бүрдүүлж, тэдний оролцоог хангах олон талт арга хэмжээг зохион байгуулж, нийгмийн идэвхтэй гишүүн болгоход дэмжлэг үзүүлнэ.			
69.	“Залуучуудын хөгжлийн төв”-ийг шинээр байгуулж, стандартын дагуу тохижуулан, тэднийг бүх чиглэлээр хөгжүүлэх орчинг бүрдүүлж, үйл ажиллагааг тогтмолжуулна.	Улсын төсөв	ГБХЗХГ
Зорилт 1.22. Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тасралтгүй хөгжүүлэх тэдний эрэлт хэрэгцээнд суурилсан, хөгжил оролцоог хангасан салбар дундын зохицуулалт хийж, нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлнэ.			
70.	Ахмад настны насан туршдаа суралцах боломжоор ханган, насан туршийн боловсрол төв, нэгжүүдтэй хамтарсан сургалт, уулзалт арга хэмжээг тогтмол зохион байгуулж, аж ахуйн нэгж, байгууллагуудад ахмадуудын зөвлөх үйлчилгээг нэвтрүүлнэ.	-	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар /цаашид ХХҮГ гэх/, аймгийн Ахмадын хороо
71.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрэлт хэрэгцээнд суурилсан сэтгэлзүйн болон сэргээн засах сургалт, арга хэмжээг тогтмол зохион байгуулж, хөгжих, оролцох боломжийг сайжруулах багц арга хэмжээг авч хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийг байгуулна.	ХЭДС	ХХҮГ
ШИНЖЛЭХ УХААН			
Зорилт 1.23 Орон нутгийн онцлогт тулгуурлан их, дээд сургуулийг шинээр байгуулна.			
72.	Аймгийн 90 жилийн ойн хүрээнд “Өвөрхангайн түүх, өв соёл”, “Эдийн засгийн хөгжил” сэдэвт эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурал зохион байгуулж, эмхэтгэл ном хэвлүүлнэ.	Орон төсөв	Аймгийн ЗДТГ
73.	Орон нутгийн эрэлт хэрэгцээнд үндэслэн их, дээд сургуулиудын магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрүүдийг судална.	-	Аймгийн ЗДТГ, Политехник коллеж
Зорилт 1.24. Техник, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын үйл ажиллагааг тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн бодлогод нийцүүлэн хөгжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тулгуурлан төгсөгчдийг ажлын байраар хангана.			
74.	Техникийн болон мэргэжлийн боловсролын “элсэлт-сургалт-төгсөлт”-ийн бүх шатанд нийгмийн	Улсын төсөв	Аймгийн ЗДТГ,

	түншлэгч, ажил олгогч, мэргэжлийн холбоодын үүрэг оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэн, хамтын ажиллагааг тасралтгүй өргөжүүлнэ.		Политехник коллеж
75.	Техник, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, улсын болон гадаад улсын хөрөнгө оруулалттай хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрт төгсөгчдийг хамруулах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.	Улсын төсөв, төсөл хөтөлбөр	Аймгийн ЗДТГ, Политехник коллеж
76.	Техник, мэргэжлийн боловсролд E сургалт, инновацийн төвийг байгуулан, цахим үнэлгээ, бүртгэл мэдээллийн системийг хөгжүүлнэ.	Улсын төсөв	Аймгийн ЗДТГ, Политехник коллеж
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ			
Зорилт 1.25. Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангаж, халамжаас хөдөлмөр эрхлэлтэд шилжүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулж, нийгмийн дундаж давхаргыг нэмэгдүүлнэ.			
77.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хэрэгжүүлж, төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээлд хамруулах, ажилд зуучлах замаар 1500-аас доошгүй ажлын байр бий болгоно.	ХЭДС	ХХҮГ
78.	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээлэл хүргэх үйлчилгээнд хамрагдах зорилтот бүлгийг оновчтой сонгож зохион байгуулна.	ХЭДС	ХХҮГ
79.	Харьцангуй бага хэрэглээтэй дунджаас доогуур түвшний өрхийн ажил эрхэлдэггүй иргэнийг мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад шат дараалан хамруулж, хөдөлмөр эрхлэхэд зуучилна.	ХЭДС	ХХҮГ
80.	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн бүртгэл, мэдээллийг нийгмийн даатгалын байгууллагатай хамтран зохион байгуулна.	Орон нутгийн төсөв, ХЭДС	ХХҮГ, НДХ
81.	Эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр, эрхлэлтийг дэмжин, гадаад болон дотоодын санхүүжилттэй төсөл, хөтөлбөрт хамруулж өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.	Улс, ХЭДС, төсөл хөтөлбөр	ХХҮГ
Зорилт 1.26. Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган, төр, хувийн хэвшлийн байгууллагууд ажилтан, үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.			
82.	Сумдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын гишүүдийг чадавхжуулна.	Орон төсөв нутгийн	ХХҮГ
83.	Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдлын зөвлөлөөс үзлэг шалгалт, зөвлөн туслах, сургалт арга хэмжээг зохион байгуулна.	Орон төсөв нутгийн	ХХҮГ
84.	Хувийн хэвшлийн байгууллагуудын цалин хөлс, хөдөлмөрийн харилцаанд хяналт тавьж ажиллана.	Орон төсөв нутгийн	ХХҮГ
Зорилт 1.27. Нийгмийн халамжийн үйлчилгээг оновчтой болгон, зорилтот өрх, иргэний амьжиргаанд дэмжлэг үзүүлж, хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.			

85.	Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд үндэслэн зорилтот бүлгийн өрхүүдийг оновчтой тодорхойлж, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа өрхөд нөхцөл байдлын судалгаа хийнэ.	-	ХХҮГ
86.	Зорилтот бүлгийн өрхүүдийн дунд бүлэг байгуулан олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээгээр дэмжиж ажиллана.	-	ХХҮГ
87.	Нийгмийн халамжийн бүрдүүлэх материалыг цахимаар хүлээн авч, иргэдэд шуурхай үйлчилнэ.	Орон нутгийн төсөв, төсөл, хөтөлбөр	ХХҮГ
88.	Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлыг сумдад хийж, шаардагдах зардлыг төсөвт тусган хэрэгжүүлнэ.	Орон нутгийн төсөв, төсөл, хөтөлбөр	ХХҮГ
89.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог сайжруулж, тэдний эрхийг хангах төрийн бус байгууллагуудад чадавжуулах сургалтыг зохион байгуулна.	Орон нутгийн төсөв, төсөл, хөтөлбөр	ХХҮГ

Зорилт 1.28. Нийгмийн даатгалын мэдээллийг бүрэн цахимжуулан, иргэд даатгуулагчдад үйлчилгээг ил тод, шуурхай хүртээмжтэй хүргэх, хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчдыг нийгмийн даатгалд хамруулж, тэдний нийгмийн баталгааг хангана.

90.	Нийгмийн даатгалын цахим мэдээллийн сан бүрдүүлэн, архивын цахим лавлагааны үйлчилгээг жигдрүүлж, иргэд, даатгуулагчдад шуурхай үйлчилгээ үзүүлнэ.	Улсын төсөв	Нийгмийн даатгалын хэлтэс /цаашид НДХ гэх /
91.	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг биелүүлж, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон малчдын нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	Улсын төсөв	НДХ
92.	Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын хурлын үйл ажиллагаанд шаардагдах тоног төхөөрөмжөөр хангаж, хурлыг цахимаар зохион байгуулах ажлыг үе шаттай эхлүүлнэ.	Улсын төсөв	НДХ
93.	Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын талаарх дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр сургалт, арга хэмжээ зохион байгуулна.	Улсын төсөв, орон нутгийн төсөв	НДХ

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ

Зорилго: Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарыг эрчимтэй хөгжүүлж, эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, олон тулгуурт эдийн засаг бүхий өрсөлдөх чадвартай аймаг болно.

САНХҮҮ, ТӨСВИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Зорилт 2.1. Төсвийн төлөвлөлт, хариуцлагыг сайжруулж, цахим системийг хөгжүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангана.

94.	Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавина.	Орон төсөв нутгийн	Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс /цаашид СТСХ гэх/
95.	Төсвийн ил тод байдлыг хангах замаар шилэн дансны мэдээлэл байршуулалтад тогтмол хяналт тавьж, хариуцлага тооцон ажиллана.	Орон нутгийн төсөв	Санхүүгийн хяналт, аудитын алба
96.	Сумдын татварын орлогыг төлөвлөгөөний дагуу биелүүлэх хариуцлагын тогтолцоог бүрдүүлж, орлого биелэлтийн үр дүнгээр санхүүжилтийг олгоно.	Орон нутгийн төсөв	СТСХ, аймгийн Татварын хэлтэс
97.	Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөрийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, барагдуулах ажлыг зохион байгуулна.	Орон нутгийн төсөв	Санхүүгийн хяналт, аудитын алба, сумдын Засаг дарга.
Зорилт 2.2. Татварын бүх төрлийн үйлчилгээг цахимжуулж, татварын үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад жигд хүртээмжтэй хүргэнэ.			
98.	Татвар төлөгчдийн эрх зүйн мэдлэг, татварын багц хуулийн шинэчлэлийг таниулж, татвар төлөх сэтгэлгээ хандлагыг өөрчлөн, заавар, зөвлөгөө, сургалтыг тогтмол зохион байгуулна.	Орон нутгийн төсөв	Татварын хэлтэс
99.	Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, салбар компаниудыг орон нутгийн татварын албанд бүртгэлтэй болгон, татварын баазыг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлж, төсвийн орлогыг нэмэгдүүлнэ.	Орон нутгийн төсөв	Татварын хэлтэс
Зорилт 2.3. Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлж, цахим санхүүгийн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлнэ.			
100.	Иргэдэд хөрөнгийн зах зээл, үнэт цаасны арилжаанд оролцох чадавхыг нэмэгдүүлэх сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.	Хувийн хэвшил	СТСХ
101.	Иргэдийг мөнгөн тэмдэгтийн зохистой хэрэглээнд уриалж, банк, даатгалын байгууллагын аюулгүй цахим бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлнэ.	Орон нутгийн төсөв	СТСХ, Монгол банкны салбар
102.	Иргэн бүрийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлж, “Хуримтлалтай иргэн” аяныг мэргэжлийн болон бичил санхүүгийн байгууллагатай хамтран үе шаттай хэрэгжүүлнэ.	Орон нутгийн төсөв	СТСХ, НТБТ, Монгол банкны салбар
Зорилт 2.4. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан эх оронч худалдан авалтыг дэмжиж, тендер шалгаруулалтын үйл ажиллагааг сүүлийн үеийн дэвшилтэт технологид тулгуурлан явуулж хүний оролцоог багасгана.			
103.	Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжинэ.	-	Орон нутгийн өмчийн газар /цаашид ОНӨГ гэх/
104.	Улс, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих	-	ОНӨГ

	худалдан авах ажиллагааны 90 хүртэлх хувийг цахимаар зохион байгуулна.		
105.	Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн хөгжил, шинэчлэлийг тогтмол ашиглаж, хэрэгжүүлнэ.	-	ОНӨГ
106.	Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагчид, хөндлөнгийн төлөөллүүдийг мэргэшүүлэх, давтан сургах ажлыг зохион байгуулж, бүх шатны худалдан авах ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг тогтмол явуулж, хөндлөнгийн хяналтыг сайжруулна.	Орон төсөв	нутгийн ОНӨГ
107.	Монгол улсын Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоолын дагуу төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогыг аймгийн хэмжээнд зохион байгуулна.	-	ОНӨГ
108.	Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдэд холбогдолтой журмуудыг шинэчлэн батлуулж, төлөөлөн удирдах зөвлөл, удирдах зөвлөл, удирдлагын багийг компанийн засаглалын сургалтад хамруулах, жилийн үйл ажиллагааг дүгнэх, хариуцлага тооцох ажлыг хэрэгжүүлнэ.	-	ОНӨГ
109.	Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоот аж ахуйн нэгжүүдэд ногдол ашгийн төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангана.	-	ОНӨГ

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭР

Зорилт 2.5. Орон нутгийн хөгжил, эдийн засгийн өсөлтийг хангах уул уурхайн орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулж хариуцлагатай уул уурхайг дэмжинэ.

110.	Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлж, өргөтгөнө.	Аж ахуй нэгжийн хөрөнгө	Аймгийн ЗДТГ, БОАЖГ, Арвайхээр сумын ЗДТГ, Баянтээг ХК
111.	Улсын болон хувийн хэвшлийн хөрөнгөөр уул уурхайн орд газруудад хийгдэх геологи, хайгуул судалгааны ажилд хяналт тавьж, ажлын тайлан, үр дүнг хүлээн авч, мэдээллийн сан үүсгэнэ.	Орон төсөв	нутгийн БОАЖГ, МХГ
112.	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг хариуцлагыг сайжруулж, ашиглалтыг хуулийн хүрээнд явуулна.	Орон төсөв	нутгийн БОАЖГ, МХГ
113.	Уул уурхайн олборлох салбарт төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын 3 талт бүтцийг хөгжүүлж, нийгмийн хариуцлагын гэрээг хэрэгжүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангана.	Орон төсөв	нутгийн БОАЖГ, МХГ

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭР, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ

Зорилт 2.6. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг тооноос чанарт шилжүүлж, сүргийн зохистой бүтцийг хадгалах замаар түүхий эд, бүтээгдэхүүний экспортлох боломжийг нэмэгдүүлнэ.

114.	Уянга сумын Таац, Жаргалант, Шуранга, Ар цармын сарлаг үхрийн биологийн онцлог, ашиг шимийн түвшин тогтоох судалгааны арга зүйг батлуулах ажлыг зохион байгуулна.	-	Хүнс, хөдөө аж ауйн газар /цаашид ХХААГ гэх/, Уянга сумын ЗДТГ
115.	Нарийнтээл сумын “Тээлийн улаан” нутгийн шилмэл ямаа, Уянга сумын нутгийн шилмэл сарлагийн үнээнд зохиомол хээлтүүлэг хийнэ.	-	ХХААГ, холбогдох сумдын ЗДТГ
116.	Аймаг, сумдын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг орон нутгаас бүрдүүлэх зорилгоор төр хувийн хэвшлийн түншлэлээр орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгуулан түүнийг газар, талбай, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, өвс тэжээлийн агуулах барьж, 1000-аас доошгүй га атаршсан газрыг хашаалж, малын тэжээл тариална.	Орон төсөв, нутгийн төсөл, хөтөлбөр	Аймгийн ЗДТГ, ХХААГ, ОНӨГ
117.	Мал эмнэлгийн газрын лабораторийг мах, сүүнд шинжилгээ хийдэг /эм, тарианы үлдэгдэл илрүүлэх/ тоног төхөөрөмжөөр хангана.	Орон төсөв нутгийн	Аймгийн Мал эмнэлгийн газар /цаашид МЭГ гэх/
118.	Мал эмнэлгийн нэгдсэн системийн үйл ажиллагааг өргөжүүлж, мал эмнэлгийн гэрчилгээг бичих, баталгаажуулах, хянахад шаардлагатай төхөөрөмжөөр бүх сумын малын эмч, мэргэжилтнүүдийг ханган, мал эмнэлгийн үйлчилгээг цахимжуулна.	Орон төсөв нутгийн	МЭГ
119.	Арвайхээр суманд хүнсний ногооны механикжсан зоорийн зураг, төсөв хийлгэн барих ажлыг эхлүүлнэ.	Орон төсөв, нутгийн төсөл, хөтөлбөр	ХОХБТХ, ХХААГ
120.	Арвайхээр сумын хүн амын хаврын улирлын махны хэрэгцээг хангах нөөц бүрдүүлнэ.	Орон төсөв нутгийн	ХОХБТХ, ХХААГ
121.	“ӨВ-Түншлэл-2021” үзэсгэлэн худалдаа, нэгдсэн арга хэмжээ зохион байгуулна.	Орон төсөв нутгийн	ХОХБТХ, ХХААГ
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН ХАРИЛЦАА			
Зорилт 2.7. Хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөлтийн дагуу дэд бүтцийг хөгжүүлэх замаар орон нутагтаа тав тухтай ажиллах, амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.			
122.	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг тус тус боловсруулан батлуулж, хэрэгжүүлнэ.	Орон төсөв нутгийн	ХОХБТХ, ГХБХБГ
123.	Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газрын кадастр, үнэлгээ, газрын мониторинг, биржийн байнгын ажиллагаатай системийг хөтөлж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.	Улсын төсөв	ГХБХБГ
124.	Аймгийн болон сумдын төв, суурин газруудад хийгдсэн хаягийн зургийг засварлаж, хаягжилтын	Улсын төсөв	ГХБХБГ, сумдын

	мэдээллийн сан үүсгэж, төрийн байгууллагуудын мэдээллийн бусад сантай холбоно.		ИТХ, ЗДТГ
125.	Арвайхээр суманд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 150 айлын нийтийн орон сууцны барилгын ажлыг дуусгаж ашиглалтад оруулна.	Хувийн хэвшлийн хөрөнгө	ХОХБТХ, ГХБХБГ
126.	Төрийн албан хаагчид, өндөр настан, бага, дунд орлоготой иргэдэд чиглэсэн түрээсийн орон сууц хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор эхлүүлнэ.	Орон нутгийн төсөв, Хувийн хэвшил	ХОХБТХ, ГХБХБГ
127.	Арвайхээр сумын гэр хорооллын айл өрхүүдийг инженерийн дэд бүтцэд хэсэгчлэн холбох зураг, төсөл боловсруулна.	-	ХОХБТХ, ГХБХБГ
128.	Өндөр насжилттай буюу 2000 оноос өмнө ашиглалтад орсон олон нийтийн барилга байгууламжуудыг паспортжуулах ажлыг эхлүүлнэ.	-	ГХБХБГ
129.	Хайрхандулаан, Хужирт сумдад хэрэгжиж буй инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажлыг гэрээний хугацаанд гүйцэтгүүлж ашиглалтад оруулна.	Улсын төсөв, төсөл хөтөлбөр	ХОХБТХ, ГХБХБГ
130.	Сант, Төгрөг суманд цэвэр усны хангамжийг сайжруулж, шугам сүлжээ шинээр барих, Баянгол, суманд усан сан шинээр барина.	Улсын төсөв	ХОХБТХ, ГХБХБГ
131.	Бүрд, Есөнзүйл сумдын хот суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж батлуулна.	Сумын төсөв	ГХБХБГ холбогдох сумдын ЗДТГ
132.	Төрийн байгууллагуудын барилга, байгууламжид дулааны тоолуур суурилуулах ажлыг зохион байгуулна.	Орон нутгийн төсөв	ХОХБТХ, ГХБХБГ холбогдох сумдын ЗДТГ
133.	Орон сууцнуудын дундын өмчлөлийн шугам сүлжээ, цахилгаан шат, нийтийн эзэмшлийн зам талбай зэрэг эд хөрөнгийн өмчлөлийг тодорхой болгох, засвар, ашиглалтыг мэргэжлийн байгууллагад хариуцуулах, түүний үйл ажиллагаанд тавих хяналт, зохицуулалтыг сайжруулна.	-	ХОХБТХ, ГХБХБГ
134.	Газар зохион байгуулалт, нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний дагуу сумдын төвийн тохижилтын ажлыг эхлүүлнэ.	Улсын төсөв	ХОХБТХ, холбогдох сумдын ЗДТГ
135.	Арвайхээр, Хужирт сумдад үерээс хамгаалах далан сувгийн байгууламжийн зураг, төсвийг боловсруулна.	Улсийн төсөв	ХОХБТХ
136.	Бүрд, Есөнзүйл сумдын 10 кВ-ын агаарын шугамын ажлыг барьж дуусгана.	Улсын төсөв	ХОХБТХ
137.	Арвайхээр, Хархорин сумдад цахилгаан дамжуулах шугамын өргөтгөл шинэчлэлт хийнэ.	Дэлхийн банкны төсөл	ХОХБТХ

138.	Арвайхээр суманд мэдээлэл, харилцаа холбооны худаг сувагчлал, шугам сүлжээний өргөтгөл хийнэ.	Улсын төсөв		ХОХБТХ
139.	“Арвайхээр-Хужирт-Бат-Өлзий”, “Чойр-Мандалговь-Арвайхээр” чиглэлийн авто замуудыг шинээр барих ажлын зураг, төсвийг хийлгэнэ.	Улсын төсөв		ХОХБТХ
140.	Улсын чанартай авто замын дагуух Есөнзүйл, Хайрхандулаан сумдыг хатуу хучилттай авто замаар холбох ажлын зураг, төсвийг хийлгэнэ.	Орон төсөв	нутгийн	ХОХБТХ
141.	Бат-Өлзий сумын Орхон гол, Цагаан гол, Могойтын гол, Үүртийн тохойн төмөр бетонон гүүрүүд, Могойтын голоос Орхон голын гүүр хүртэл 6.7 километр сайжруулсан авто замыг тус тус ашиглалтад оруулна.	Улсын төсөв		ХОХБТХ
142.	Төв талбайн “Соёмбот багана”-ыг тохижуулах, Т.Намнансүрэн, П.Гэндэн, Б.Ренчинпэлжээгийн нэрэмжит гудамжуудын замын хайс, хашлагыг сэргээн засварлаж, гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэл, гэрлэн дохио, замын тэмдэг, тэмдэглэгээг сайжруулна.	Орон төсөв	нутгийн	ХОХБТХ
143.	Ардын уран зохиолч Д.Пүрэвдоржийн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнг Өвөрхангай аймгаас төрөн гарсан алдартнуудын /урлагийн, соёлын, цэргийн алдартнуудын мэдээллийг агуулсан/ цэцэрлэгт хүрээлэн болгон тохижуулж эх оронч хүмүүжил олгох орчинг нэмэгдүүлнэ.	Орон төсөв	нутгийн	ХОХБТХ, Цэргийн штаб
ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО				
Зорилго: Нутгийн захиргааны байгууллагын бүх түвшинд засаглалын хариуцлага, шударга ёсыг мөрдүүлж, цахим технологид тулгуурласан, иргэдэд тэгш боломж олгодог, оновчтой бүтэц бүхий төрийн албыг бэхжүүлнэ.				
ЁС ЗҮЙ, ХАРИУЦЛАГАТАЙ ТӨРИЙН АЛБА				
Зорилт 3.1. Төрийн байгууллагуудын чиг үүргийг оновчтой тодорхойлж, давхардлыг арилгах, үйл ажиллагааны уялдааг хангах замаар үр ашигтай бүтэц бүхий мэргэшсэн чадварлаг, тогтвортой, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлнэ.				
144.	Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн шинжилгээ хийж, давхардал, хийдлийг арилган, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгоно.	Орон төсөв	нутгийн	Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /цаашид ТЗУХ гэх/, Төрийн албаны салбар зөвлөл
145.	Төрийн байгууллагуудын барилгын ашиглалтын байдалд, үнэлгээ хийж үйл ажиллагааг төрөлжүүлэн, ашиглалтын менежментийг сайжруулна.	Орон төсөв	нутгийн	ТЗУХ, ОНӨГ
146.	Төрийн албан хаагчийн сургалт хөгжил, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлнэ.	Орон төсөв	нутгийн	ТЗУХ, Төрийн албаны салбар

				зөвлөл
ЦАХИМ ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ				
Зорилт 3.2. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг цахимжуулж, төрийн үйлчилгээг хялбаршуулан, зардал хэмнэх тогтолцоонд шилжүүлж, төрийн албан хаагчийн ажиллах орчинг сайжруулна.				
147.	Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд “Call center” үйлчилгээг бүрэн нэвтрүүлж, операторын үйлчилгээг жигдрүүлнэ.	Орон төсөв	нутгийн	ТЗУХ
148.	Аймгийн төрийн байгууллагуудад дотоод удирдлагын нэгдсэн системийг нэвтрүүлж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагааг цахимжуулна.	Орон төсөв	нутгийн	ТЗУХ
149.	Төрийн албаны сонгон шалгаруулалтыг цахимаар зохион байгуулж, үйл ажиллагааг нь ил тод болгоход шаардлагатай техник хэрэгслээр хангана.	Орон төсөв	нутгийн	ТЗУХ
150.	Төрийн байгууллагуудын интернэтийн хурд, чанарыг сайжруулж, мэдээлэл технологийн ажилтныг чадавхжуулна.	Улс, нутгийн төсөв, хөтөлбөр	орон төсөв,	ТЗУХ
151.	Төрийн бодлого, шийдвэрийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдэд хүргэхэд олон нийт, төрийн бус байгууллагатай хамтран ажиллана.	Орон төсөв	нутгийн	ТЗУХ
152.	Хайрхандулаан, Тарагт сумдын Засаг даргын Тамгын газрын барилгыг ашиглалтад оруулж, аймгийн Нутгийн удирдлагын ордон, Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газрын барилгын засварын ажлыг гүйцэтгүүлнэ.	Улсын төсөв		Аймгийн ЗДТГ
153.	Багийн Засаг дарга нарыг унаажуулж, төрийн байгууллагуудын автомашин, тоног төхөөрөмжийн засвар, шинэчлэлтийг хийнэ.	Улс, нутгийн төсөв	орон төсөв	ТЗУХ
ГАДААД ХАРИЛЦАА				
154.	Аймгийн хамтын ажиллагаатай гадаад орнуудын хот, мужуудтай олон улсад өрсөлдөхүйц инноваци, шинэ технологи, мэдлэг шингэсэн үйлдвэрлэл, үйлчилгээний бизнес төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулна.	Орон төсөв	нутгийн	ТЗУХ
155.	Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын төсөл, хөтөлбөрийн байгууллагуудтай идэвхтэй ажиллагааг өрнүүлж, эдийн засаг, нийгмийн салбарт хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	Орон төсөв	нутгийн	ТЗУХ
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛТОЙ ИРГЭН, ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАСАН НИЙГЭМ				

Зорилт 3.3. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хүний эрхийг хамгаалах, хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг оновчтой арга, хэлбэрээр зохион байгуулна.

156.	“Бүх нийтийн эрх зүйн боловсрол” хөтөлбөрийн хүрээнд цахим технологид суурилсан арга хэлбэрээр эрх зүйн сургалт, сурталчилгааны гарын авлага, материал бэлтгэн түгээх, төрийн байгууллагуудын сургалт, мэдээлэл хариуцсан ажилтнуудыг чадавхжуулан тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулна.	Орон төсөв, хөтөлбөр	нутгийн төсөл	Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс /цаашид ХЭЗХ гэх/
157.	Сумдад эрх зүйн танхим, булан байгуулах ажлыг эхлүүлж, сайн дурын эрх зүйн хөтчүүдийг бэлтгэн, иргэдэд хууль зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл өгөх, хууль, тогтоомжийн лавлагаа олгох, бусад шаардлагатай хууль зүйн туслалцааны үйлчилгээг нэвтрүүлнэ.	Орон төсөв, хөтөлбөр	нутгийн төсөл	Аймгийн ЗДТГ, ХЭЗХ
158.	Монгол Улсын хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр, нутгийн захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрээр аймаг, сумдын нэгдсэн сан, бүртгэлийг эрхлэн хөтлөх, санг баяжуулах үйл ажиллагааг тогтмолжуулна.	Орон төсөв	нутгийн	Аймаг, сумдын ЗДТГ
159.	Төрийн болон иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын үйл ажиллагаа, шийдвэрт хяналт-үнэлгээ хийж, хүний эрхийн зөрчилд дүн шинжилгээ хийнэ.	Орон төсөв	нутгийн	ХЭЗХ, ХЭУКомисс
160.	Хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг нэмэгдүүлж, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн, олон нийтийн оролцоонд тулгуурласан хяналт, шалгалтын үйл ажиллагаа явуулж, үр дүнг тооцно.	Орон төсөв	нутгийн	Аймгийн ЗДТГ, ХЭЗХ
161.	Аймагт хэрэглэгчийн эрхийг хамгаалах, шударга бус өрсөлдөөнтэй тэмцэх үүрэг бүхий ажилтныг ажиллуулж, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэгтэй төрийн бус байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлэн, бизнесийн байгууллагуудын шударга бус өрсөлдөөн, үнийн хөөрөгдөл, бүтээгдэхүүний чанар байдлыг хянаж, монополь үүсэхээс сэргийлж ажиллана.	Орон төсөв	нутгийн	Аймгийн ЗДТГ, ХЭЗХ
162.	Орон нутаг дахь жендэрийн тэгш байдлыг хангах бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлж, аж ахуйн нэгж, байгууллагууд, олон нийтэд жендэрийн боловсрол олгох, нөлөөллийн үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулна.	Орон төсөв	нутгийн	Аймгийн ЗДТГ, НБХ

АВЛИГАГҮЙ ЗАСАГЛАЛ

Зорилт 3.4 Олон нийтийг соён гэгээрүүлэх, хууль тогтоомжийг сурталчлах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

163.	Авлигыг үл тэвчих үзэл хандлагын талаарх нийтлэл, нэвтрүүлгийг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлж, түүнийг цахим сүлжээ болон хэвлэл мэдээллийн байгууллагаар олон нийтэд түгээн дэлгэрүүлэх ажил зохион байгуулна.	Орон төсөв	нутгийн	Аймгийн ЗДТГ, ХЭЗХ
164.	Нутгийн захиргааны бүх байгууллагуудад авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулж, үр дүнг тооцон ашиг сонирхлын зөрчил гаргуулахгүй байх арга хэмжээ авч	Орон төсөв	нутгийн	Аймгийн ЗДТГ, ХЭЗХ

	хэрэгжүүлнэ.		
ХҮН, НИЙГМИЙН АМАР ТАЙВАН БАЙДАЛ			
Зорилт 3.5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг хамгаалах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлж, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг сайжруулна.			
165.	“Аюулгүй иргэн-Амар тайван Өвөрхангай” хөтөлбөр арга хэмжээг, үргэлжүүлэн хэрэгжүүлнэ.	Орон төсөв, хөтөлбөр	нутгийн төсөл ХЭЗХ Аймгийн Цагдаагийн газар
166.	Сумдын төвийн гэр хорооллын гудамж, нийтийн эзэмшлийн талбай, замын теле-камер, гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх, хүчин чадлыг сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Орон төсөв -	нутгийн Аймгийн Цагдаагийн газар
167.	Улсын чанартай авто замын дагуу байрлах шатахуун түгээх станц, үйлчилгээний цэг, тээврийн хэрэгслийн зогсоолуудад телекамер байршуулах, тээврийн хэрэгслийн улсын дугаар танигч LPR камерыг суурилуулах ажлыг аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоотойгоор шийдвэрлэнэ.	Хувийн хэвшил	Аймгийн Цагдаагийн газар
168.	Нийгэмд түгээмэл буй согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зам тээврийн осол, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, таслан зогсоох олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.	Орон төсөв	нутгийн Аймгийн Цагдаагийн газар
169.	Архидан согтуурахтай тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлж, архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Орон төсөв	нутгийн ЭМГ
170.	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож, мал хулгайлах гэмт хэргийг бууруулна.	Орон төсөв	нутгийн Аймгийн Цагдаагийн газар
Зорилт 3.6 Хууль сахиулах болон хяналтын байгууллагууд, тэдгээрийн алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.			
171.	Байгууллагын болон төрийн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг эрчимжүүлэн, сүүлийн үеийн өндөр хүчин чадал бүхий техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, дэмжлэг үзүүлнэ.	Улс, нутгийн төсөв	орон Аймгийн ЗДТГ, Архивын тасаг
172.	Аймгийн Прокурорын газрын барилга, Богд, Хужирт сумдын Цагдаагийн тасгийн барилгуудыг шинээр барих ажлыг эхлүүлж, шаардлагатай тавилга, техник хэрэгслийг шийдвэрлүүлнэ.	Улсын төсөв	ХОХБТХ, ГХБХБ, аймгийн Прокурорын газар, Цагдаагийн газар
173.	Олон нийтийн цагдаагийн урамшуулал, хувцас, тусгай хэрэгслийн хангалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.	Улс, нутгийн төсөв	орон Аймгийн Цагдаагийн газар